

Н.Хавх

*МУИС-ийн буддын соёлын
судалгааны төвийн захирал
доктор, профессор.*

**Монголчуудын газар эзэмших уламжлалт тогтолцоо
хийгээд нүүдлийн соёл иргэншил.
(мал аж ахуй)**

1990 оноос хойш, манай Монголд газрыг хувийн өмч болгох, эс болгох талаар нилээд ширүүн маргаан өрнөсний цаана монгол үндэстэн оршин тогтнох, эс оршин тогтнохын асуудал буй. Бидний өвөг дээдэс олон мянган жилийн турш, нүүдлийн мал аж ахуй соёл иргэншил эрхэлсээр ирсэн нь монгол хүн гар урлал, аж үйлдвэр, газар тариалан эрхлэх дургүй, чадвар мөхөсөөс (тийм чиг байгаагүй) болсных бус монгол нутгийн эх болсон байгаль, газартай зохицон амьдрах зайлшгүй шаардлагынх аж. Монголчууд далай тэнгисээс алслагдсан өнөөгийн хэлээр бол “эх газрын эрс тэс уур амьсгал”-тай газар нутагт амьдарсаар ирсэн, өнөөдөр ч мөн адил, цаашдаа ч тийм л байх байх. Энэ нь ямар учиртай газар нутаг юм бэ гэхлээр хур тунадас ядмагаас ургамлын гарц арвин биш, хөрсний хар шороон хучлаг нимгэн, энэ бүхнээр газрын хөрс эвдрэхдээ амархан, экологийн аюул ихтэй, нүүж суухгүйгээр нэг нутаг дээр урт хугацаагаар мал хариулах бололцоо муу. Хэрэв газрыг хаа хамаагүй хагалж, тариа тарьж, малыг олон зуун, мянган толгойгоор нь нэг бэлчээр нутагт маллаваас газрын даац хэтэрч, тариалангийн талбай ч, малын бэлчээр ч эвдрэн сүйдэж, сүүл сүүл рүүгээ хэнд ч хэрэггүй элсэн цөл болон хувирна. Эдийн засгийн газар зүйн эрдэмтдийн тооцоолсноор манай нутгийн 3 орчим хувьд л газар тариалан эрхлэхэд экологийн аюулгүй юм гэсэн. Тэгэхээр ийм онцлогтой газар нутгаа сүйтэгчихгүй, тэгснээр үндэс угсаагаа устгачихгүй байх ямар арга зам байна вэ гэдэг асуулт зүй ёсоор тавигдана.


Өнгөрсөн бол ирээдүй биш гэсэн мэргэн үг бий. Бидний өвөг дээдэс олон мянган жилийн турш нүүдлийн мал аж ахуй голлон эрхэлж, нүүдэлчдийн соёл иргэншил хөгжүүлж ирсний цаад утга гэвэл Монгол нутгийнхаа газар дэлхийг эвдэж сүйтгэчихгүйгээр улс орноо авч явах гэснийх. Энэ л аж ахуйгаа, соёл иргэншлээ эрхэлсээр цэцэглэн мандаж дэлхийн тэн хагасыг эзлэж ч явсан, мөн цагийн эрхээр уруудан доройтож бусдын эрхшээлд орж, дахин цэцэглэн мандаж байсан түүхэн замнал бий. Нүүдлийн соёл иргэншилтэй байсан нь ямар ч атугай уруудалт доройтлын шалтгаан огтхон чиг биш, харин монгол үндэстний оршин

тогтнох үндэсийн үндэс болсоор ирсэн. Энэхүү өгүүлэлд, үндэсний тусгаар тогтнолоо аюулд унагачихгүй байя гэвэл монголчууд газраа хэрхэн эзэмшихэв, засаг захиргааны хуваариа хийхэд үүнийг хэрхэн анхаарахав, энэ талаар буурал түүх юу хэлнэв гэдэг талаар товч авч үзье.

Газар улсын мэдэлд байсан учир. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын хувьд бол газар, бэлчээр улсын байх нь гарцаагүй аж. Ер нь ийм чиг уламжлалтай явж ирсэн. Хэдий тийм ч малчин олон түмэн, хот айл бүрт өөр өөрсдийн гэсэн эзэмшил хаваржаа, өвөлжөө, намаржаа, зуслангийн бэлчээр нутаг бас бий. Энэ нь хэдийгээр тэдний хувийн өмч биш ч гэсэн тэдний эдлэх, эзэмших эрх нь амьдралын явцад тогтон бий болсон хавь ойрын хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн улсын газар нутаг. Ингэлээ гээд газрын түрээс гэгдэхээр утгаар улсад татвар үл төлнө: харин улсын иргэн бүр улсдаа, төрдөөн эзэн хаандаа алба барих, татвар төлөх учиртай. Монгол угсаатны оршин тогтнох эдийн засгийн үндэс суурь, дэвсгэр нь бэлчээрийн мал аж ахуй байсаар олон мянган жилийн нүүр үзсэн, одоо ч, цаашдаа ч тийм байхаас өөр замгүй: лав л энэ бүхэн монголын нутаг дэвсгэрийн өнөөгийн энэ эх газрын эрс тэс уур амьсгал өөрчлөгдөөгүй цагт хэвээр байхаас өөр газаргүй. Мал сүргийг жилийн дөрвөн улирал даган нүүдэллүүлнэ, монголчууд мал сүргийнхээ аясыг даган хангай, хээр, говийн хооронд "өөдөө", "уруугаа" нүүнэ: зуд, ган болоход хаана бололцоотой байнав, тийшээгээ нүүдэл хийнэ. Энэ бүхний цаана байгальтай зохицон амьдрах зүй тогтол үйлчилнэ, байгалийн шалгарал явагдана: хэрэв ёсоор нь, номоор нь нүүж, сууваас байгалийн шалгаралыг амжилттай даван туулна, мал сүргийн чанар сайжирна: эс нүүж сууваас шалгаралыг эс даван, мал аж ахуй бүхэлдээ уруудан доройтно, мал сүргийн чанар чансаа муудна. Нутагтаан хөндлөн гулд туун нүүдэл хийн, дөрвөн улирлын цаг агаарын аяст тохируулсан мал аж ахуйгаа эрхлэн ирсэн хэрэг. Монголчуудын дорнын онцлогтой нүүдлийн соёл иргэншлийн оршин тогтнох үндэс суурь нь газар улсынх юм бол, монгол угсаатны соёл иргэншил доройтох үндэс суурь гэвэл газар, бэлчээрийг хувьчлах явдал яриагүй мөн байх.

Газрыг хувьчлах, нийгэмчлэхийн утга учир, тэдгээрийн туйлшралаас гарах үр дагавар. Нийгмийн амьдралд газрыг хувьчлах, нийгэмчлэхийн аль аль нь байж болно, болохоор барахгүй байх ёстой аж: чухам хэрхэх нь тухайн тохиолдолд өмчийн нийгмийн хийгээд хувийн шинж аль тал руугаа туйлширсан байнав гэдгээс шалтгаална.

өмчийн хувийн шинж



өмчийн нийгмийн шинж

1. Хувийн шинж нь нэн давамгайлсан, өмчийн хэлбэр. Хувьчлагдсан газар нь улсын эрх ашигт бараг үйлчлэхээ больж байгаа тохиолдол.
2. Хувийн шинж нь давамгайлсан, өмчийн хэлбэр. Хувьчлагдсан газар нь улсын эрх ашигт бага, хувь хүмүүсийн эрх ашигт илүү үйлчлэх.
3. Хувийн шинж нь нийгмийнхтэй дээд зэргээр шүтэн барилдсан, тэнцвэрт тогтолцоог бий болгож чадсан өмчийн тогтолцоо.
4. Нийгмийн шинж давамгайлсан өмчийн хэлбэр. Нийгэмчлэгдсэн газар нь улсын эрх ашигт их, хувь хүмүүсийн эрх ашигт бага үйлчлэх тохиолдол.
5. Нийгмийн шинж нь нэн давамгайлсан өмчийн хэлбэр. Нийгэмчлэгдсэн газар нь хувь хүмүүсийн эрх ашигт бараг үйлчлэхээ больж байгаа тохиолдол.
6. Зөвхөн хувийн шинж дагнасан өмчийн хэлбэр. Хувьчлагдсан газар нь нийгмийн эрх ашигт огт нийцэхээ больсон тохиолдол.
7. Зөвхөн нийгмийн шинж нь дагнасан хэлбэр. Нийгэмчлэгдсэн газар нь хувь хүмүүсийн эрх ашигт огт үйлчлэхээ больсон тохиолдол.

Хэрэв өмчийн нийгмийн шинж дагнан туйлширч (зураг 1-ын 7) түүнээс болж, улс нийгмийн хөгжил зогсонги байдалд орсон бол газрыг хувьчлахаас өөр замгүй, хэрэв өмчийн хувийн шинж дагнан туйлширч (зураг 1-ын 6), түүнээс болж, улс нийгмийн хөгжил задрал бутралд орсон бол газрыг нийгэмчлэхээс өөр замгүй. Хувьчлал, нийгэмчлэл хоёр нь зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг тал: эхнийх нь билгийн, хоёр дахь нь аргын тал, тэдгээрийн аль нэгийг нь өрөөсгөлөөр хийвээс алдаа эндэгдэлд орно, улс орноо доройтуулна: улс орны тухайн үеийн байдалд нь тохируулж, тэдгээрийн шүтэлцээний хир хэмжээг зөв ухаарч хувьчлал, нийгэмчлэлийг хийх учиртай аж. Хирээс хэтрүүлэн нийгэмчлэсний хор холбогдлыг "социалист" гэгдэж байсан нийгмийн түүхээс бид мэднэ. 1990 оноос хойш хувьчлал хийсэн, хийх нь зайлшгүй байсан: харин

хувьчлалыг хирээс нь хэтрүүлэх замд орсоод байгаа мэт. Монголд газрыг хувьчилна гэдэг нь газар, бэлчээрээ хувь хүмүүст хуваагаад, хувийн өмч болгоод өгчихийн нэр биш, улсын газрыг эзэмших хувь хүмүүсийн эрхийг нь нэмэгдүүлэх тухай л асуудал байхаар төсөөлөгдөнө. Эс тэгвээс газар, бэлчээрийн том, жижиг олон өмчтөн гарч ирнэ: хувьд шилжсэн буюу тухайн тэр хүний хувийн газар нутагт намаржаа, өвөлжөө, хаваржаа, зуслангийн нутаг бүгд байж яавч чадахгүй: зүй нь гэхэд зуд, ган болоход хэдэн зуун км газар нүүнэ, зун болоход говийнхон хангай руу нүүнэ: нэг хүнд ийм өргөн уудам нутгийг хувьд өгнө гэж үгүй. Тэд зөвхөн өөр өөрсдийнхөө л эрх ашгийн үүднээс аливаа асуудалд хандана, бусдын малыг өөрийн эзэмшил нутагт бэлчээрлүүлэх сонирхол тэдэнд үгүй. Газрыг хувьд шилжүүлснээр малчин бүр дөрвөн улиралд чөлөөтэй нүүх бололцоогүй болно, тэгэх тусмаа хангай, говийн хооронд нүүдэл хийж чадахгүйгээс мал сүрэг орчинтойгоо зохицон байх хууль зөрчигдөнө, бэлчээрийн мал аж ахуй уналтанд орно, монголын нийгмийн амьдралын бусад салбараа авч явдаг стратегийн ач холбогдолтой нүүдлийн мал аж ахуй унахаар, монгол үндэстэн бараг бүх талаараа уналтанд орж тусгаар тогтнолоо алдана. Монгол хүний хоол унд, хувцас хунар, гэр орон, ёс заншил, эрхлэх аж ахуй, амьдралын хэвшил, газар өмчлөл гээд л бүгд л оёороороо өөрчлөгдөнө. Монголын түүхэнд газраа гурван удаа хувьчилж байж, гэхдээн гол төлөв харийнханд эзлэгдсэн тэр түүхэн үедээ. Анх тэргүүнээ Уйгарын хаант улсын үед бэлчээр феодалуудын хувийн өмч болж, тэд малын бэлчээрийн төлөө өөр хоорондоо байлдан дайтсаар 90 гаруйхан жилийн дараа дотоодын тэмцэл, байлдаанаас болж задран бутран мөхсөн гэдэг¹. Уйгарчууд Алтайн чанадаас монгол нутагт орж ирсэн угтаан харь хүмүүс агаад Уйгарын хаант улсын үед монголчууд өөрсдөөн бус, харийнхан монголын газар нутгийг хувийн өмч болгосон хэрэг. Уйгарын хаант улс бол монгол угсаатны уналт, гудайлтын үеийн улс. Хоёр дахь удаагаа бэлчээр, газар хувьчлал Кидан улсын үед хийгдсэн². Кидан улс нь бас л монгол угсаатны уналтын үеийн нийгмийн амьдрал нь ихээхэн хэмжээгээр хятадчлагдсан улс: өөрөөр хэлбэл, өмнөт хөршийн харьяанд багталцаж байсан хэрэг. Лав л Кидан гүрний оршин тогтнолын сүүлийн үед монгол угсаатны тусгаар тогтнол нэн хүнд болж монголчууд удаа дараа тэмцэлд боссон нь XIII зуунд хүчирхэгжин гарч ирэхийн холын угтвар нөхцөл болов. Энэ удаа монголын газар, бэлчээр мөн л монголчуудын өөрсдийн

¹ БНМАУ-ын түүх. УБ. 1984, 131 дэх тал

² Мөн тэнд. 135 дахь тал.

гараар бус тэр үед монголд ноёрхолоо тогтоосон өмнөт гараар хувьчлагдсан хэрэг. Гурав дахь удаа монголын газар, бэлчээр 1906 онд эх суурь тавигдаж 1915-1921 онд хүчээ авсан хувьчлал. 1906 онд Бээжинд тариачин хятадыг монголд нүүлгэн оруулах товчоо байгуулан, монгол газрыг тариалангийн талбай, хятад хувь хүмүүсийн хувийн өмч болгож эхэлсэн байна. 1915 онд гурван улсын гэрээгээр Монгол Хятадын автомат эрхтэй нэгэн муж болсон нь газрыг хувийн өмч болгох ажилд чөлөөт зам нээж өгсөн бололтой. Тэр үед шинжилгээний ажлаар монголд ирсэн оросын судлаачдын тэмдэглэлд "Урьд монголын мал мянга мянгаар бэлчиж, айлууд арваараа, зуугаараа нутаглаж байсан газар одоо нэг ч сүрэг мал, ганц ч гэр үзэгдэхгүй болжээ. Цөмийг уудам хөндий, өргөн голтой хангай нутгаас зайлуулж, худгаас өөр усгүй бэлчээр, өвс муутай говь тал руу хөөжээ"³ гэжээ.

Социализмын үед газар хувьчлах тухай огт яригдаагүйн учир гэвэл, марксизмийн сургаалд социалист нийгэм нь нийгмийн өмчинд тулгуурласан байх учиртай. Дөрөв дэх удаагаа Монголд, 1990 оноос хойш газрыг хувьд шилжүүлэх хувьчлах тухай яриа, бодлого өрнөсөн. Энд мөн л суурин соёлтой гадаад хүчирхэг улс нөлөөлсөн болов уу.

Газар, улмаар бэлчээрийг хувьд шилжүүлснээр гарах үр дагаварын сонгодог жишээг урд хөршөөсөө бид олж харж болох мэт. Олон мянган жил бэлчээрийн мал аж ахуй эрхэлсээр ирсэн, тухайн үедээ Монгол улсын маань нэг хэсэг болж байсан урд хөршийн нутагт бэлчээрийг хувьчилснаас хойш бас нилээд хэд хэдэн арван жил болж. Тэнд өрх болгон хааш хаашаагаа цөөхөн км багаахан бэлчээрийг хувийн өмч болгон өгч, өрх бүрийн бэлчээрийн хилийг тогтоож, төмөр утсаар, мөн овоогоор хилийн тэмдэг тавьж, улмаар, бэлчээрээс гарах маргааныг шийдэж байх үүрэгтэй бэлчээрийн цагдаагийн албыг бий болгосон юм байна. Урьд, жилийн дөрвөн улиралд нүүдэллэж зун, намар, өвөл, хаврын байгаль цаг агаартай зохицолдон, байгалийн шалгаралыг туулан, туулж чадсан ихэнх нь байгальтай зохицох аль илүү шилдэг шинжийг олж удам угсаагаа сайжруулж, бүтцэнд нь шалгарал жинхэнэ ёсоороо явагдаж байсан мал сүрэг нэгэн нутаг дээрээ жилийн дөрвөн улирлыг өнгөрөөнө, байгальтай зохицох чадвар нь ямар нэгэн хэмжээгээр алдагдана, байгалийн шалгарал жинхэнэ ёсоороо явагдахаа болино, жилийн дөрвөн улирал үүрэггүй шахуу болно, мал сүргийн бүтэц дэхь байгалийн шалгарал бараг үүрэггүй үгүй болно, мал сүргийн чанар чансаа муудна. Энэ бол бэлчээрийн мал аж ахуй биш,

³ Мөн тэнд, 267 дахь тал.

суурин мал сүрэг. Бэлчээрийн даац хэтэрнэ, газрын хөрс эвдэрнэ, тэр газар ургамал ургахаа болино, эцсийн дүнд мал сүрэг, байгаль хоёрын хүйн холбоо суларч байгалийн зохицуулалт алдагдана. Онолын хувьд л лав ийм байх учиртай. Газар хувьчилснаас хойш эхлээд тэмээ, дараа нь адуу, дараа нь үхэр ихээр хорогдсон, улмаар зарим нь бараг үгүй болсон, малын махны чанар муудсан (бодвол, ер нь ашиг шимийн чанар болов уу) мэдээ бий. Нилээд нутгийн бэлчээр нь эвдэрч, өвс ургамал ургахаа больсон, тэр газар бэлчээрийн ургамлын үр цацахаар болж байгаа гэсэн. Бас малын (бодвол бог малын) тоо ихээр өсч 70 гаруй сая болсон тухай ярьдаг. Хэрэв тийм бол энэ нь бэлчээрийг хувьчилсаны сайн чигийн үр дагавар мөн болов уу даа, аль эсвэл, амьтны тоо толгой, хүнс тэжээлийнх нь нөөцтэй тохирч байх тэр хууль зөрчигдөж, бэлчээр эвдэрснээс байгаль өөрөө амьтны тоо толгойг зохицуулах үүрэггүй болсных юм болов уу. Үүнээс малын тоо толгой хэт өсөн, бэлчээрийн даац улам ихсэж эргээд бэлчээрээ эвдэх гайд орох учиртай. Ийм чигийн баримт тэнд байгаа нь байгаа л байх.

Ямар ч атугай бидний өвөг дээдэс газар, малынхаа бэлчээрийг төрөөр мэдүүлэх зэргээр: нэн гүн гүнзгий утга агуулгатай, нэн холын бодолтой явж ирсэн нь, улс үндэстний тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндсийн үндсийг бат чанга хамгаалалтанд байлгах нэгэн зүйлийн нөхцөл болж чадсан хэрэг. Монголчууд хичнээн ч уруудан доройтлоо гэхэд бусдад уусаж үгүй болохгүй, өөрийн гэсэн үндэсний онцлогоо хадгалсаар ирсний цаад учир үүнд ч бас бий хэмээн бодогдоно.

Засаг захиргааны хуваарийг

Улсын уламжлалт хил хязгаарын учир.

Бэлчээрийн мал аж ахуйд

Нэг ч хүний бай, бүхэл бүтэн улс үндэстний

шүтэлцүүлэхийн учир

ч бай организм орчинтойгоо зохицох хуулиар

л явна, засаг захиргааны хил хязгаарыг тогтоох нь ч мөн адил. Аль нэгэн улсынх ч бай, улс доторхи манайхаар бол аймаг хошууных ч бай хил хязгаар нь хэн нэгэн хүн, хаад ноёдын үзэмж сонирхолоор газар нутгаа хаа хамаагүй хуваах ч юм уу, эсвэл Монгол улс бүгд тэдэн аймагтай, аймаг бүр нь тэдэн сумтай, сум бүр нь тэдэн багтай байх ёстой гэсэн механик хуваарилалтын аргаар тогтоогддог тийм зүйл биш аж. Хил хязгаар нь амьтанд бол амьдрахын төлөө урт удаан хугацааны туршид бусад амьтан болон байгальтай хийсэн тэмцлийн явцад тогтоогдон бий болсон, тэдний хүнс хоолоо илүү ихээр олж идэх, дайсан этгээдээсээ өөрийгөө илүү сайн хамгаалж чадах, үр төл нь зохицон өсөн өндийх илүү их бололцоотой тийм нутаг газрын хүрээ заагийг хэлнэ. Монгол угсаатны улсын хил нь хойшоогоо Байгаль далай, урагшаагаа Хятадын Их цагаан хэрэмд

тулж очсон нь бас л учиртай: Байгаль далайгаас цаашаага бол битүү хөвч тайга, сүрлэг өндөр уул нуруунууд, тэнд бэлчээрийн мал сүрэг эрхлэх бололцоо нэн хязгаарлагдмал. Хятадын Их цагаан хэрмээс цааш бол далай тэнгисийн зөөлөн дулаан уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралын ялгарал гээд байх юм бага (хяр дээр нь хэрэм барьсан уул нуруу нь монгол нутагт далайн уур амьсгалыг эс оруулна), мөн бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд бүүрч тохиромжгүй учир хойшоо ч, урагшаа ч лав орж нутаглаваас тэнд далай тэнгисийн зөөлөн дулаан уур амьсгалтай, үүнээс болж байгалийн шалгарал явагдаж эс чадна, бэлчээрийн мал оршин тогтноход нэн бэрх, орос, хятадын нутаг бол бэлчээрийн биш суурин мал аж ахуйн нутаг. Бидний өвөг дээдэс нутгийнхаа хойт хилээ Байгаль далайн эргээр, урд хилээ Хятадын Их цагаан хэрмээр тогтоосны цаад учир ийм аж. Мэдээж уул ус, газрын доорх баялаг, түүх дурсгалт газар зэрэг бусдад өгөх, эс өгөх гээд хил хязгаарыг тогтооход харгалзан тооцох өдий төдий зүйл бий.

Хангай, говийг хосолсон уламжлалт хил хязгаарын учир. Хүннүчүүд түүхэнд мэдэгдэж байгаагаар бүүр МЭӨ III зуунд л гэхэд газар нутгаа хойноос нь урагш гурав хувааж, төвөө эзэн хаан нь баруун зүүн гараа түүний итгэлт ноёдууд захирч байсан уламжлалтай. Энэ нь чухамдаа хангай, говь, хээрийг хослуулсан, зуны цагт говийнхон “өөдөө”, намрын цагт “уруугаа” нүүх бололцоог бүрэн дүүрэн бүрдүүлсэн, ийм нүүдлийг сайтар хийж чадсан малчид, мал сүрэг хоёрын аль аль нь байгалийн шалгаралыг даван туулж, малчин хүний мал маллах эрдэм ухаан, туршлагаа арвижуулан баяжуулахад, мал сүргийн бүтэц сайжрах, ашиг шимийн нь чанар чансаа нь нэмэгдэхэд шууд чиглэгдсэн засаг захиргааны хуваарь.

Засаг захиргааны уламжлалт энэ хуваарь олон мянган жил хадгалагдсаар, мөрдөгдөж баримтлагдсаар ирсэн нь бас л бэлчээрийн мал аж ахуй эрхлэх шаардлагынх байж. Хил хязгаарыг хойноос нь урагш нь бөмбөрцгийн босоо шугамаар биш, баруунаас нь зүүн тийш нь хэвтээ шугамаар хийвэл хийчихээр л, гэвч тэгсэнгүй. Энд зарчмын том ялгаа бий. Хэрэв Монгол нутгаа бөмбөрцгийн хэвтээ шугамаар гурав хувааж, аймгийн хилийг хийвээс нэг аймаг нь зөвхөн хангайн, хоёр дахь нь зөвхөн хээрийн, гурав дахь зөвхөн говийн бүсийн аймаг болно. Тэгээд газар нутгийг нь тухайн тэр аймагт нь хадаж өгвөөс, нэг аймгийн хилийг давж нөгөө аймагт нүүх бололцоог халваас, лав л говийнхон жилийн дөрвөн улиралд говьдоо хадагдаж, зуны аагим халуунд мал нь бэлчээрлэж, идээшилж өгөхгүй, тарга тэвээр, энерги авч чадахгүй, өвөл, хаврын тарчиг, хатуу улиралыг даван туулах чадвар нь мөхөсдөнө, мал сүргийн

орчинтойгоо зохицож чадаагүйгээс үхэж үрэгдэх нь их болно, ялангуяа зуднаар олноороо үхнэ. Төрөөс засаг захиргааны хуваарийг буруу хийснээс байгальтайгаа зохицох чадвар доройтно, тоо толгой нь зүй бусаар хорогдоно, сүргийн чанар бүтцийн хувьд ч, ашиг шимийн хувьд ч муудна гэсэн үг. Засаг захиргааны ийм маягийн хуваарийн үед бэлчээрийн мал сүрэг нь байгалийн шалгаралд орох бололцоо нь хязгаарлагдмал: орчин организмтай зохицон амьдрах хууль зөрчигдөнө гэсэн үг. Хангайд нэн хүйтэн болоход говь, хээр тал руугаа нүүж болох л байх. Ингэснээр мал сүргээ орчинтойгоо зохицон амьдрах бололцоотой болгоно, хүйтэнд хөлдөж үхэж хорогдохоос аварч болох л талтай. Хэрэв засаг захиргааны хуваарыг дээрх маягаар хийвээс тэр бололцоо ч бас алдагдана. Монголчууд зуны улиралд говиос хээр, хангай руугаа, намар болохоор буцан нүүж, мал аж ахуйгаа эрхлэх түүхэн зайлшгүй зүйл болох нь олон мянган жилийн амьдрал, практикаар батлагдан нотлогдсон зүйл. Төр засгаас түүнд нь тааруулан тохируулан засаг захиргааны хуваариа хийж байсан нь нэн мэргэн.

Үндэстэн уруудан доройтож, ялангуяа суурин соёлтой бусдын эрхшээлд ороход засаг захиргааны уламжлалт тогтолцоо ямар нэгэн хэмжээгээр алдагдаж байж. Энэ бол ёс, номоороо болж байгаа зүйл бараг мөн. Учир нь суурин иргэд суурин мал аж ахуйгаа эрхэлнэ, газар бэлчээрийг ихэнх тохиолдолд хувь хүмүүс өмчилнө: Монголыг эрхшээлдээ оруулсан суурин иргэд түүнийг өөрийн соёлд оруулах бодлого явуулах нь, монголчууд ч түүнд орох нь хууль: харин ямар хэмжээгээр орох вэ гэдэгт л хамаг учир бий. Хангай, говийг хослуулсан энэхүү засаг захиргааны уламжлалт хуваарь нь Хүннүгээс гараа нь эхэлсэн түүхэн урт замыг туулахдаа ямар нэг хэмжээгээр өөрчлөгдөж, шинэчлэгдэж байсан ч, 1921 оноос эхлэн Монголд орж ирсэн европын суурин соёл иргэншлийн нөлөөгөөр бараг тэр чигээрээ халагдан солигджээ. Нутгаа олон тооны аймгуудад бөмбөрцгийн босоо бус, хэвтээ шугамаар хуваасан байна.

Аймгийн засаг захиргааны хуваарийг хангай, хээр, говийг хослуулан хийх уламжлал Хүннү, Сяньби, Жужаны үед хадгалагдаж байснаа, Киданы үед зарим талаар алдагдаж, Монголын эзэнт гүрний үед сэргээгдэж, 1921 он хүртэл хадгалагдаж байснаа, дээр өгүүлснээр европын суурин соёл иргэншлийн нөлөөгөөр өөрчлөгдөж, 1960 он хүртэл 18 аймаг, 1990 оноос 21 аймаг болон өөрчлөгдөж, бараг бүрмөсөн гээгдсэн гэж хэлж болохоор байна.⁴

⁴ Х.Цолмон. Проблемы соотношения обновления и традиции монгольского государства. Автореферат на соиск. Учен. Степ. Кандидата политической наук. УБ. 1998. Таб 1-ийн 3, таб 2-ийн 3, таб 3-ийн 3.


Засаг захиргааны уламжлалт тогтолцоо, хуваарь орхигдож: хангай, говь, хээр зааглагдаж: нутаг дэвсгэр олон тооны аймгуудад, аймгууд нь олон арван сумдад, сумд нь олон багуудад хуваагдсанаар мал сүргийн байгальтай зохицох чадвар, сүргийн чанар, ашиг шим, удмын шалгарсан сайн шинж зэрэг хангай, говийн хооронд чөлөөтэй нүүж сууж байх үед, байгалийн шалгарал ес номоороо явж байх үед бий болсон шинж чанар тогтворгүй болно, өөрлөгдөнө, гэхдээн муудах тал руугаа гэсэн үг. Өнгөцхөн бодоод үзэхэд, зуны цагт хангайд зуссан, говьдоо зуссан говийн хоёр айлын мал сүргийн зуданд өртөх нь хоёр өөр л байх байх: хангайд зуссан говийн айлын мал сүргээс хорогдох нь бага, говьдоо зуссан говийн айлийн мал сүргээс хорогдол их байхаар төсөөлөгдөнө. Аж үйлдвэр, газар тариаланг хөгжүүлэх үүднээс нутаг дэвсгэрээ 21 байтугай 31 аймагт ч хувааж болох байх: гэхдээн энэ бүхэн нь монгол орны эдийн засгийн гол салбар болох нүүдлийн мал аж ахуйн хэвийн байдлыг алдагдуулахгүй байлгах, малчид хангай, говийн хооронд чөлөөтэй нүүж, сууж байх бололцоотой байхаар аймгуудын, сумуудын, багуудын хоорондын харьцааг зохицуулах өдий төдий хувилбар байхыг үгүйсгэхгүй. Хэрэв асуудлыг энэ талаас нь сайтар шийдэж чадсан бол заавал цөөн аймагтай, аймаг бүрийн нутаг нь хангай, говь, хээрийг багтаасан, хосолсон, дамнасан байх албагүй юм.

Засаг захиргааны, дөрвөн улиралын бэлчээр бүхий нэгжтэй байхын учир. Зэрлэг амьтад жилийн дөрвөн улирал тус бүрт таарч тохирсон бэлчээртэй, гэхдээ тэдний дөрвөн улиралд идээшлэх бэлчээрийн хил хязгаар байгалийн шалгаралын явцад тэднээс байгальтай болон өөртөө нь өрсөлдөгч бусад ан амьтантай хийх тэмцлээр тогтоогдоно: тэнд алдах, хил хязгаар алдаатай тогтоогдох явдал гарахгүй: бэлчээрийн мал сүрэг ч мөн л дөрвөн улиралын бэлчээрийг дагана: энэ бол тэдний амьдрах, оршин тогтнох үндэс: бэлчээрийн хил хязгаарыг тэд өөрсдөө биш хүн тогтооно: хэрэв хүмүүс дөрвөн улиралын шүтэлцээ, бэлчээрийн мал, бэлчээр хоёрын зохицолдолгоо зэргийг сайтар ухаарахгүйгээр хил хязгаар буюу засаг захиргааны нэгжийг тогтоовоос, тэр нэгж нь дөрвөн улиралын бэлчээрийг багтаах ёстой атал, зөвхөн нэг эсвэл зөвхөн хоёр, эсвэл зөвхөн гурван улирлын бэлчээртэй болчихсон байвал тэр нь бэлчээрийн мал сүргийн байгальтай зохицох чадварыг бууруулж, улмаар алдагдуулна: тэнд байгалийн шалгаралын хууль бүрэн гүйцэд үйлчилж эс чадна. Монгол нутгийн засаг захиргааны нэгжийн тоо 1725 он хүртэл 4, Манжийн ноёрхолын үед 82, 1911-1915 онд уг тоо тэр хэвээрээ⁵, 1921-1990 онд 306 (18

⁵ Мөн тэнд. 17 дахь тал.

аймаг, 306 сум), 1990 оноос хойш аймгийн тоо 21, сумын тоо түүнд харгалзан улам өссөн байна⁶. Газар зүйн шинжлэх ухааны эрдэмтэн Г.Нямдаваа “Алтайн уулархаг нутгийн мал аж ахуйн газар зүйн асуудал” УБ., 1995 хэмээх дэд докторын зэрэг горилсон бүтээлдээ Ховд аймгийн сумдыг жилийн дөрвөн улиралын бэлчээртэй, гурван улиралын бэлчээртэй, хоёр улиралын бэлчээртэй гэж гурав хуваагаад жил жилийн мал сүргийн тоо толгойн өсөлтийг судалж, дөрвөн улиралын бэлчээртэй сумдын малын тоо толгой өссөн, гурван улиралын бэлчээртэй сумдын малын тоо толгой буурсан, хоёр улиралтай суманд уг тоо бүүр бууралттай байгаа тухай өгүүлсэн байна. Энэ нь сүүлийн хоёр тохиолдолд байгалийн шалгарал гүйцэт сайн явагдаж чадаагүйгээс сүргийн чанар муудаж, өвөл, хаврын хатуу улиралд сул дорой нь харьцангуй олноор үхэж үрэгдэж байна гэсэн үг болов уу. Ямар ч атугай онолын үүднээс бодоод үзэхэд жилийн дөрвөн улиралын бэлчээртэй сумдад мал сүрэг, байгаль хоёр олж, сүргийн бүтцэд шалгарал ёс номоороо явагдаж, чанар нь сайжирч тэнцвэрт (зураг 2) улмаар баруун гар талын хэлбийлттэй бүтэцтэй болно.

Давтамж (тоо)



а-зүүн талын хэлбийлттэй тогтолцоо
 б-тэгш хэмт тогтолцоо
 в-баруун талын хэлбийлттэй тогтолцоо

зураг 2

1. Санамсаргүй нь давамгайлдаг цөөнх. Дааганы уралдаанд бол баян ходооднууд.
2. Санамсаргүй нь зайлшгүйтэй хэвийн байдлаар шүтэлцүүлсэн олонх. Дааганы уралдаанд бол барианд дунд болон дундаас дээш, доош орж ирж буй бүх даага.
3. Санамсаргүйг өөртөөн дээд зэргээр шингээсэн зайлшгүй бүхий сүргийн сор манлай. Дааганы уралдаанд бол айрагдсан дааганууд.

Гурван улиралын бэлчээртэй сумдад мал сүрэг, байгаль хоёр төмөр махбодыг олж, сүргийн бүтцэд шалгарал бүрэн гүйцэт явагдаж эс чадна,

⁶ Мөн тэнд 19 дэх тал, Таб 3-ийн 3.

сүргийн чанар ямар нэгэн хэмжээгээр муудаж, зүүн гар талын хэлбийлттэй болох нь хууль. Малын ашиг шимийн хэмжээ чанар ч (сүү саалийн гарц, тарга тэвээр, мах сүүний чанар гэх мэт) тэр л хирээр муудах ёстой байх. Хоёр улиралын бэлчээртэй сумдад мал сүрэг, байгаль хоёрын шүтэлцээ алдагдана, усан махбодтой болно: байгалийн шалгарал ёс номоороо явж эс чадна: сүргийн чанар нэлээд хэмжээгээр муудаж, бүтэц нь зүүн гар тал руугаа нилээд хэмжээгээр хэлбийсэн (зураг 2-ын 1), өөрөөр хэлбэл, сүргийн дотор чанараар муухан малын эзлэх жин, өмнөх хоёр тохиолдлоос даван гарсан, малын ашиг шимийн чанар ч бас тэр хэмжээгээр муухан талдаа байх болов уу. хэрэв ямар нэгэн хот айл өвөлжөөгөө тойроод л хаваржаад, намаржаад, зусаад байвал (урд хөршид бол бүүр өвөлжөөндөө хаваржина, намаржина, зусна, учир нь тэнд бэлчээр хувьчлагдсан, бэлчээрийн мал сүргийг суурин болгосон) мал сүрэг, байгаль хоёрын шүтэлцээ ихээхэн хэмжээгээр алдагдана, тэдний хоорондын нь хүйн холбоо бүүр суларна, сүргийн тоо, чанар хэзээ хэзээнээс илүү тогтворгүй болно, бүтцэнд нь байгалийн шалгаралын хууль үйлчлэхээ болино: ямар ч атугай сүргийн чанар байх ёстой дээд хэмжээгээр доройтно: харин шалгарал явагдахгүй болохоор мал сүргийн муу нь ч, сайн нь ч үхэж үрэгдэхгүй болж тоо толгой нь өсөж болох өөрөөр хэлбэл, тоо нь нэмэгдэж, чанар нь муудах талтай. Манай урьд хөршид бэлчээрийн малыг суурьшуулснаас хойш малын (бог болов уу) тоо толгой нэмэгдсэний цаад учир шалтгаан үүнд л байх ёстой мэт.

Дээр өгүүлсэн бүхнээс дараах дүгнэлт гарна. Үүнд:

1. Хэрэв газар, улмаар бэлчээрээ хувьд шилжүүлвээс монголын нүүдлийн мал сүргийн амьдралд байгалийн шалгарлын хууль үйлчлэхээ болино, өөрөөр хэлбэл уг хууль зөрчигдөнө, мал сүргийн чанар чансаа муудна, ашиг шим нь доройтно, эцэс сүүл рүүгээ мал сүрэг уналтанд орж болзошгүй.
2. Хэрэв газар, бэлчээр хувьд шилжвээс нүүдэл суудал хаагдаж, бэлчээрийн даац хэтрэн газар бэлчээр эвдэрч, цөлжилт хүчтэй явагдана, тэнд ямар ч соёл иргэншил оршин тогтнохын аргагүй болно.
3. Газар, бэлчээр сүйдэж, нүүдлийн мал аж ахуй уналтанд орвоос монгол угсаатан оршин тогтнох орон зай үгүй болно гэсэн үг.